



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 474

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 290,913,290.00 (хоёр зуун ерэн сая есөн зуун арван гурван мянга хоёр зуун ерэн) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Орон нутгийн өмчийн газраас төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132006046
24-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 09 дүгээр сарын-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт

"Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
 нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгслийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалддах доод үнэ (төгрөг)
1	Гинжит трактор Б10М.0110-1Е	2010-12-31	ш	1	290,913,290.00	290,913,290.00	5,000,000.00
Нийт дүн					290,913,290.00	290,913,290.00	5,000,000.00 (таван сая)